



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

Тооллогын комисс байгуулах
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл, 71 дүгээр зүйл, 72 дугаар зүйлийн 72.1, 72.4 дэх заалт, 73 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Тушаах :

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгийн тооллогыг зохион байгуулах үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Н.Ганболд	Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга
Гишүүн:	Ц.Гантуяа	Ерөнхий нягтлан бодогч
	Б.Мөнхбаатар	Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Б.Янжинлхам	Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
	Д.Дариймаа	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Д.Будхүү	Мэдээлэл, технологийн албаны дарга
	Нарийн бичгийн дарга:	Нярав Д.Золбаяр

2. Үндсэн хөрөнгийн тооллогыг 2022 оны 06 дугаар сарын 13-ний өдрөөс 06 дугаар сарын 17-ны дотор холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж, тооллогын дүнг танилцуулахыг Комиссын дарга /Н.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132003207

ТӨБЗГ тушаал-/2022